



БАЯНХОНГОР АЙМАГ  
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 18 өдөр

Дугаар 1/75

Хөхбүрд

“Монголиан Тунлин Баян Зэс” ХХК-д  
ус ашиглах зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5, 28, Зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-ийн 1.14 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчны газрын 2025 оны 226 дугаар тоот албан бичгийн дагуу ус ашиглуулах дүгнэлтийн дагуу Мандалхайрхан 1 дүгээр багийн нутагт орших “Монголиан Тунлин Баян Зэс” ХХК-ийн хайгуулын чиглэлээр үйл ажиллагаа явуулахад ус ашиглах зөвшөөрөл олгосугай.

2. Холбогдох хууль тогтоомж, гэрээний хэрэгжилт, ус ашиглалтын байдалд хяналт тавьж, Усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай мэдээ тайлан болон ус ашигласны төлбөрийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор төлүүлж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын Байгаль хамгаалагч (М.Ганбаатар)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Гансүх)-д даалгасугай.

ДАРГА  Т.БЯМБАДОРЖ



